

МАГАДЛАН ИТГЭМЖЛҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 237 дугаар тушаалын хавсралтаар баталсан журмын 4.1-д заасан дагуу дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Магадлан итгэмжлэлд хамрагдах тухай албан хүсэлт;
2. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
3. Хугацаа дуусаж байгаа магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар;
4. Магадлан шинжлэх шалгуурын дагуу хийсэн өөрийн үнэлгээний тайлан;
5. Тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр (анх магадлан итгэмжлэлд хамрагдах байгууллагууд чанарын төлөвлөгөөтэй ажиллах) хэрэгжүүлсэн тайлан;
6. Сүүлийн 2 жилийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд;
7. Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын болон шинжээчдийн өгсөн зөвлөмжийн биелэлт /хийсэн ажлын тайланг тодорхой бичих/;
8. Магадлан итгэмжлүүлэх үйлчилгээний төлбөр төлсөн баримт:

Байгууллага нь нэмэлтээр Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 499 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж буй эрүүл мэндийн байгууллагын танилцуулга” (Маягт №1)-ыг хөтөлж ирүүлнэ.

МАГАДЛАН ИТГЭМЖЛҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ БАЙГУУЛЛАГЫН МАТЕРИАЛ БҮРДҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

1. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж буй албан бичиг

- Хүсэлт гаргаж буй албан бичиг нь албан хэрэг хөтлөлтийн стандарт шаардлагыг хангасан байх;
- Албан бичигт яам, газрын нэрийг зөв бичих. Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газар;
- Албан бичгийн огноо нь материал ирүүлсэн хугацаатай тохирч байх.

2. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар

- Хүчинтэй хугацаа бүхий мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх. Хэрэв тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа дууссан бол сунгуулсан, ажлын байр өөрчлөгдсөн бол одоо байрлаж байгаа хаягийн өөрчлөлтийг хийлгэсэн байх шаардлагатай. Тодорхой шалтгаанаар зөвшөөрлийн гэрчилгээний сунгалт хийгдээгүй бол сунгагдаагүй шалтгааныг тодорхойлсон аймаг, нийслэлийн ЭМГ, тусгай зөвшөөрлийн комиссын албан бичиг, тодорхойлолтыг хавсаргана. Эрүүл мэндийн байгууллага нь тусгай зөвшөөрөл авсан бүх мэргэжлийн төрөл, чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлдэг байх шаардлагатай.
- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгээ сүүлийн 2 жилийн дотор сунгуулсан бол өмнөх гэрчилгээний хуулбарыг материалд хавсаргаж ирүүлнэ.

3. Магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар

- Тухайн эрүүл мэндийн байгууллагад олгосон А4 хэмжээтэй /жижиг/ батламжийн хуулбарыг ирүүлнэ.
- Анх удаа магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж буй байгууллагад хамаарахгүй.

4. Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтээр хийсэн өөрийн үнэлгээний тайлан

- Эрүүл мэндийн байгууллага нь өөрийн үнэлгээний тайланг www.mohs.mn вэб хуудасны “Төрийн үйлчилгээ” линкийн “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл” буланд байгаа “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт”-ээр өөрийн үнэлгээ хийх зөвлөмжийг ашиглаж тайланг бичнэ.

5. Тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан

- ЭМЯ-ны Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, хөгжлийн хэлтэс, ЭМСЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар /хуучнаар/ баталгаажуулж магадлан итгэмжлэлийн хугацаанд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хуулбарыг доорх загвараар бичсэн тайлангийн хамт ирүүлнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, хувиар тооцож дүгнэлт өгнө.
- Анх удаа магадлан итгэмжлэлд орох байгууллага нь сүүлийн 2 жилийн хугацаанд баталж, хэрэгжүүлсэн тусламж, үйлчилгээний чанарын төлөвлөгөө ба хэрэгжилтийн тайланг ирүүлнэ. Төлөвлөгөөний биелэлтийг үнэлж, хувиар тооцож дүгнэлт өгсөн байна.
- Чанарын хөгжлийн хөтөлбөр/төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан бичих загвар:

..... эмнэлгийн чанарын хөгжлийн хөтөлбөр
/төлөвлөгөө /-ийн тайлан

Хэрэгжүүлсэн хугацаа:..... оны сарын өдрөөс оны сарын –
ны өдөр

1-р зорилтын хүрээнд: /өөрийн байгууллагын дэвшүүлсэн зорилтыг бичих/

№	Хэрэгжүүлэх ажиллагаа	үйл	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1.				
2.				
3.				
	Хэрэгжилтийн хувь			

2-р зорилтын хүрээнд: /өөрийн байгууллагын дэвшүүлсэн зорилтыг бичих/

№	Хэрэгжүүлэх ажиллагаа	үйл	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1.				
2.				
3.				
	Хэрэгжилтийн хувь		

3-р зорилтын хүрээнд: /өөрийн байгууллагын дэвшүүлсэн зорилтыг бичих/

№	Хэрэгжүүлэх ажиллагаа	үйл	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1.				
2.				
3.				
	Хэрэгжилтийн хувь		

4-р зорилтын хүрээнд: /өөрийн байгууллагын дэвшүүлсэн зорилтыг бичих/

№	Хэрэгжүүлэх ажиллагаа	үйл	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
1.					
2.					
3.					
	Хэрэгжилтийн хувь			

Чанарын хөгжлийн хөтөлбөр /төлөвлөгөө /-т тусгасан зорилт, үйл ажиллагаа бүрээр тайланг бичнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцохдоо Эрүүл мэндийн сайдын 2013 оны “Хөтөлбөрийн загварыг шинэчлэн батлах тухай” 437 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан аргачлалаар үнэлнэ. Зорилт бүрийн хэрэгжилтийн хувийг үндэслэн Чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн эцсийн үр дүн /хувь/-г дүгнэнэ.

Мөн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт /11 үзүүлэлт/-ийн биелэлтийг тооцож, хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн онтой харьцуулан дүгнэлт өгсөн байна.

6. Тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд

- Өөрийн байгууллагын баталж, хэрэгжүүлж буй чанарын үзүүлэлтүүдийн баталгаажсан хувь /үйл ажиллагааны болон эрүүл мэндийн статистик үзүүлэлт гэх мэт/
- Сүүлийн 2 жилийн чанарын үзүүлэлтүүдийг суурь оны үзүүлэлтүүдтэй харьцуулан үнэлгээ өгч, дүгнэлт бичсэн байна.

7. Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын болон шинжээчдийн өгсөн зөвлөмжийн биелэлт.

Доорх загварын дагуу бичиж, хэрэгжилтийн хувийг тооцсон байна.

..... эмнэлэгт магадлан итгэмжлэлийн
шинжээчдийн өгсөн зөвлөмжийн биелэлт

Зөвлөмж өгсөн онсар ... өдөр

№	Шинжээчдийн өгсөн зөвлөмж	Зөвлөмжийн биелэлт
Бүлэг 1. Удирдлага, бүтэц, зохион байгуулалт		
1.		
2.		
Бүлэг 2. Тусламж, үйлчилгээний технологийн мөрдөлт		
1.		
2.		
Бүлэг 3. Эрүүл ахуйн нөхцөл, халдварын сэргийлэлт, хяналт, техникийн үйлчилгээ		
1.		
2.		
	Хэрэгжилтийн хувь	

Зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй бол шалтгааныг тодорхойлж тайлбар бичнэ.

..... **ЭМНЭЛЭГТ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛД**
БЭЛТГЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭМСЯ-ны холбогдох газар хэлтэс, мэргэжилтний бэлтгэл ажлын хүрээнд өгсөн зөвлөмжүүд хамаарна.

№	Шинжээчдийн өгсөн зөвлөмж	Зөвлөмжийн биелэлт
Бүлэг 1. Удирдлага, бүтэц, зохион байгуулалт		
1.		
2.		
Бүлэг 2. Тусламж, үйлчилгээний технологийн мөрдөлт		
1.		
2.		
Бүлэг 3. Эрүүл ахуйн нөхцөл, халдварын сэргийлэлт, хяналт, техникийн үйлчилгээ		
1.		
2.		

Зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй бол шалтгааныг тодорхойлж тайлбар бичнэ.

8. Магадлан итгэмжлүүлэх үйлчилгээний төлбөр

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 247 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан доор дурьдсан үйлчилгээний төлбөрөөс өөрийн байгууллагын авах үйлчилгээнд хамаарах төлбөрийг төлсөн баримтыг хавсаргана.

- Төлбөрийн баримтад гүйлгээний утга, байгууллагын нэрийг тодорхой бичнэ.

Жишээ: Гүйлгээний утга: -Магадлан итгэмжлэлийн төлбөр
- Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын төлбөр

- Төлбөр төлөх **Дансны дугаар: 900020001, Регистр: 9087443,**

Банкны нэр: Төрийн сан

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ,
ХОЛБОГДОХ ЗАРДЛЫН ЖИШИГ**

№	Үйлчилгээний нэр	Зардлын хэмжээ (төгрөгөөр)
1	1.Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөр: 2.Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв 3.Нэгдсэн эмнэлэг 4.Сум дундын эмнэлэг 5.Сум, тосгоны эрүүл мэндийн төв 6.Өрхийн эрүүл мэндийн төв 7.Клиник <ul style="list-style-type: none"> • 10 хүртэл ортой (оргүй эмнэлэг) • 11-50 хүртэл ортой • 51-ээс дээш ортой 8.Сувилал <ul style="list-style-type: none"> • 50 хүртэл ортой • 51-100 хүртэл ортой • 101-ээс дээш ортой 	 1 000 000 800 000 500 000 450 000 400 000 500 000 700 000 800 000 600 000 800 000 1 000 000
2	Магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагааны төлбөр (мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалтанд хамрагдах)	200 000
3	Бэлтгэл ажлын арга зүйн зөвлөгөө өгсөн, явцын үнэлгээ болон дунд хугацааны үнэлгээ хийж, тайлан бичсэн мэргэжилтний ажлын хөлс (1 эрүүл мэндийн байгууллагад)	15 000
4	Шинжээчийн ажлын хөлс (эрүүл мэндийн байгууллагад) <ul style="list-style-type: none"> • Багийн ахлагч • Багийн гишүүн 	55 000 45 000
5	Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн хурал: <ul style="list-style-type: none"> • Зөвлөлийн хурлын зардал (нэг удаа) • Зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс (нэг цагт) • Зөвлөлийн гишүүн бичгээр санал, дүгнэлт өгөх 	50 000 10 000 20 000

9. Нэмэлт материал

Байгууллага нь Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 12-р сарын 21-ний өдрийн 499 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж буй эрүүл мэндийн байгууллагын танилцуулга (маягт №1)-ын асуумж бүрээр тайлбарыг бичнэ.

Дээрх бүх баримт бичгийг тус тусад нь баталгаажуулсан байх шаардлагатай / гарын үсэг, тамга, огноо/ бөгөөд мөн баримт бичгийн бүрдэлтийн товъёог бичиж материалд хавсаргаж ирүүлсэн байна.

ЭМСЯ, Стратегийн бодлого төлөвлөлтийн газар